



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ЭДИЙН ЗАСГИЙН ТЭНХИМ

“Экономиксийн цагаан толгойг хэн сайн мэдэх вэ?”

Улсын XII олимпиадын удирдамж

Зорилго:

Эдийн засаг, бизнесийн удирдлагын чиглэлээр их, дээд сургуульд суралцдаг I түвшний оюутнуудын экономиксийн мэдлэг чадвар, авхаалж самбааг сорих, мэдээлэл солилцох, цаашид экономиксийг судлах сонирхлыг дэмжихэд оршино.

Оролцох оюутнууд:

- Монгол улсын эдийн засаг, бизнесийн удирдлагын чиглэлээр бакалаврын сургалт явуулдаг их, дээд сургуулиудийн микроэкономиксийн үндэс хичээлийг судалсан, макроэкономиксийн үндэс хичээлийг энэ улиралд судалж байгаа 1-р ангийн (түвшний) оюутнууд оролцоно. Түүнчлэн экономиксийн үндэс хичээлийг судалсан 1-р түвшний (ангийн) оюутнууд оролцох боломжтой.
- Оюутнууд нь баг бүрдүүлж оролцох ба баг тус бүр нэг сургуулийн 5 оюутнаас бүрдсэн байна (анги, хөтөлбөр харгалзахгүй).
- Баг бүр оноосон нэртэй байна.

Хамрах сэдэв:

1-р шатанд:

- Микроэкономиксийн үндэс хичээлийн бүх сэдэв
- Макроэкономиксийн үндэс хичээлийн дараах сэдвүүд
 - Үндэсний тооцооны систем
 - Нийт эрэлт, нийт нийлүүлэлтийн загвар
 - Нийт зарлагын загвар: Кейнсийн загвар
 - Эдийн засгийн хэлбэлзэл, бизнесийн мөчлөг
 - Сангийн бодлого

2-р шатанд:

- Нэгдүгээр шатны сэдвүүд
- Макроэкономиксийн үндэс хичээлийн дараах сэдвүүд нэмэгдэнэ
 - Мөнгөний бодлого
 - Эдийн засгийн өсөлт

Олимпиадын журам: Олимпиад 2 үе шаттай явагдана.

1-р шат нь 2016 оны 4 сарын 30-нд 11⁰⁰ цагаас МУИС-ийн хичээлийн IV, V байранд явагдана.

Энэ шатанд багуудын экономиксийн суурь мэдлэгийг тестээр шалгана. Багийн гишүүдийн авсан онооны нийлбэрээр хамгийн өндөр оноо авсан 5 багийг шалгаруулан дараагийн шатанд оролцох эрх олгоно.

2-р шат нь 2016 оны 5 сарын 15-нд явагдах ба удирдамжийг нэгдүгээр шатны шалгаруулалтын дараа оролцох багуудад хүргүүлнэ.

Шагнал:

Хоёрдугаар шатнаас шалгарсан 3 баг шагналтай.

- 1-р байр 1: өргөмжлөл, шилжин явах цом, 300000 төгрөг
- 2-р байр 1: өргөмжлөл, 250000 төгрөг
- 3-р байр 1: өргөмжлөл, 200000 төгрөг

Хувийн дүнгээр: Нийт 3 оюутан шалгаруулна.

- Тэргүүн байр 1: Өргөмжлөл, 100000 төгрөг, үнэ бүхий зүйл
- Дэд байр 1: Өргөмжлөл, 80000 төгрөг, үнэ бүхий зүйл
- Гутгаар байр 1: Өргөмжлөл, 50000 төгрөг, үнэ бүхий зүйл

Бүртгүүлэх журам:

Олимпиадад оролцох багууд **2016 оны 4 сарын 20-аас 4 сарын 27-нд** ажлын өдрүүдийн **10.00-18.00 цагийн** хооронд МУИС-ийн хичээлийн V байр 604 тоотод ирж бүртгүүлнэ. Бүртгүүлэхэд дараах зүйлс шаардлагатай.

- Багийн бүх гишүүний оюутны үнэмлэх (оюутны үнэмлэх байхгүй тохиолдолд сургуулийн сургалтын албаны тамга бүхий албан тодорхойлолт авчирна)
- Эрхийн хураамж нэг баг 25000 төгрөг

Утас: 99990544, 99901175

Хаяг:МУИС-ийн хичээлийн V байр 603 тоот

ЭДИЙН ЗАСГИЙН ТЭНХИМ

2016 он